

ГЛОБАЛЧЛАЛ БА АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Д.Намсрай*

Монгол оронд 1980-аад оноос эхэлсэн өөрчлөлт шинэчлэлтийн үйл явц 1990-ээд онд нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан хувьсгалт үйл явц болж гүнзгийрэн ардчилал зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж эхэлснээс хойш 15 жил өнгөрлөө. Энэ хугацаанд улс төр, эдийн засгийн хүрээнд томоохон өөрчлөлтүд болж өнгөрсөн байна. Шинэ үндсэн хууль, олон намын систем, жинхэнэ ардчилсан сонгууль, өмч хувьчлал, олон өмчийн хэвшил, зах зээлийн механизм, институтийг үндсэндээ бий болгожээ. Ийнхүү 15 жилийн өмнө эхэлсэн улс төр, эдийн засгийн реформийн явц, туршлага, ололт амжилт, бэрхшээл дутагдал, үр дагаврыг судалж дүгнэн цаашдын зам мөрийг сонгох, бас дэлхийн хөгжлийн хандлагатай хөл нийлүүлэн алхах нь монголчууд бидний оршин тогтнохын нэгэн үндэс юм.

Дэлхий ертөнц бүхэлдээ глобалчлалын эрин зуун руу шилжиж байна. Глобалчлалын үүсэл хөгжлийн талаар эрдэмтэн судлаачид янз бүрээр дүгнэдэг. Глобалчлалын үйл явц эрт эсвэл орчин үед эхэлсэн тухай, глобалчлал нь хөгжиж байгаа болон өндөр хөгжилтэй орнуудад ашигтай ашиггүйн тухай ялгаатай үзэл бодол байгаагаас гадна шинжлэх ухааны салбар бүрт өөр өөрийн дүгнэлт тодорхойлолт өгч байна. Нилээд хэсэг судлаачид глобалчлалыг эдийн засаг түүний дотор гадаад худалдаатай илүү холбон тодорхойлдог. Тэд үзэхдээ глобалчлал гэдэг нь эдийн засагт, ялангуяа гадаад худалдаанд либералчлалыг өргөн хэмжээгээр тунхаглаж, улс орнуудын олон талт хамтын ажиллагаа, харилцааг хөгжүүлэхийг хэлнэ гэж тодорхойлж байна. Гадаад худалдааг либералчлах, олон талт хамтын ажиллагаа, харилцааг хөгжүүлэх гэдэг нь олон улсын эдийн засгийн байгууллагууд, ялангуяа Дэлхийн худалдааны байгууллагын үйл ажиллагааны зорилготой ихээхэн ойролцоо сонсогддог. Гадаад худалдааг либералчилж үндэсний болон үндэстний ялгаварлан гадуурхахгүй бодлогыг

* МУИС, ОУХС-ийн багш, доктор(Ph.D)

баримтлах нь хөгжилтэй болоод хөгжиж байгаа улсуудын аль алинд нь эерэг сөрөг нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Зарим судлаачид арай өргөн хүрээгээр “Глобалчлал гэдэг нь дэлхийн улс орнуудын эдийн засаг, улс төр, нийгэм, соёлын харилцаа холбоо гүнзгийрч түүнийг зохицуулахад Олон улсын байгууллага ба Үндэсний засгийн газрын хамтын ажиллагааны үүрэг улам өсөхийг хэлнэ” гэсэн байна. Дэлхийн нэрт санхүүчид тооцогддог Дж. Сорос глобалчлалын тухай хэлэхдээ: “Санхүүгийн зах зээл нь тогтворгүй, тэгэх тусмаа олон улсын санхүүгийн зах зээл бүрч тогтворгүй. Түүний тогтворгүй байдал нь нийгэм эдийн засгийн хүндрэлийг үүсгэж болзошгүй Өнөөдөр дэлхийн том монополиуд, олигополиуд өөрийн ноёрхлоо тогтоохыг оролдож байна. Үүнийг зогсоож хазаарлах хэрэгтэй. Тэгэхдээ үүнийг зөвхөн Засгийн газрууд л хийж чадна. Гэтэл глобалчлалын энэ үед Засгийн газруудын үйл ажиллагаа, зохицуулалт хүчгүй болж эхэлж байна” гэжээ.

Энэ бүхнээс дүгнэн үзвэл глобалчлал гэдэг нь дэлхийн улс орнуудын харилцаа холбоо нь цаг хугацаа, хил хязгаар, орон зайнаас үл хамааран улам өргөсч байгаа, түүнийг зохицуулах шинэ хүч үүсэн бий болж байгаа эрин үе мөн. Энэ эрин үед аливаа улс орон бусад улс оронтой харилцахгүй, хаалттай оршин тогтнох боломжгүй юм. Глобалчлал нь дэлхийг бүхэлд нь хамрах нийгмийн хөгжлийн зүй тогтолт, эргэлт буцалтгүй үйл явц болсон байна.

Өнөө үед нэг улс орны хүрээнээс хальсан бүс нутгийн юмуу эсвэл олон улсын түвшинд шийдвэрлэх шаардлагатай асуудлын тоо улам ихэсч байна. Өнөөдөр хөгжиж байгаа улс орнуудаас бусад улс орон руу очиж ажиллах цагаач иргэдийн тоо өссөөр байна. Дэлхийн хэмжээнд 175 сая хүн гадаад шилжих хөдөлгөөнд оролцсон мэдээ байна. Хөгжилтэй болон хөгжиж байгаа улс орнуудын хооронд улам бүр өсөн нэмэгдэж байгаа энэ шилжих хөдөлгөөний үр дагавраар дэлхийн бараг бүх улс оронд өөр өөр зан заншил, шашин шүтлэг, хэл, соёл бүхий үндэстнүүд зэрэгцэн ажиллаж амьдарч байна. Глобалчлалын эрин үед үндэсний ёс заншил өв уламжлалаа хадгалан үлдэхийн хамт олон улсын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох шаардлага гарч байна. Ажиллах хүчний шилжих хөдөлгөөн нь улс хоорондын хүний нөөцийн хөгжил, хүний эрхийн асуудал, олон улсын боловсрол, аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэхэд нөлөөлөөд зогсохгүй олон улсын гэмт хэрэг, хүний худалдаа, ДОХ болон бусад халдварт өвчний тархалт зэрэг олон сөрөг асуудлыг ч үүсгэж байгаа билээ. Өөрөөр хэлбэл нэг улсын хэмжээнд

шийдвэрлэх боломжгүй хэд хэдэн улс, бүс нутгийг хамарсан асуудлыг үүсгэж байдаг нь эдгээр асуудлыг шийдвэрлэх талаар олон улсын хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэхийг зүй ёсоор шаардаж байна.

Монгол улс нээлттэй ардчилсан нийгэм бөгөөд бараа үйлчилгээ мэдээлэл технологиос гадна ажиллах хүчний гадаад урсгал хөдөлгөөний хувьд ч олон улсын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна.

1990-ээд оноос эхлэн Монголд зорчих гадаад иргэдийн тоо өссөөр байгаа бөгөөд тэдний нилээд нь албан ажил, аялал жуулчлалаар ирж байхад нилээд нь манай улсад түр болон бүр хугацаагаар ажил эрхлэн амьдарч байна.

Улсын хилээр нэвтэрсэн гадаадын зорчигчдын тоо, улсаар

	Орсон			Гарсан		
	2003	2004	2005	2003	2004	2005
БҮГД	204 845	305 117	344 688	193 807	297 813	338 561
АНУ	5 570	9 549	10 234	5 535	9 120	10 587
Австрали	2 247	3 473	3 465	2 042	3 567	3 413
Англи	2 859	4 970	5 224	2 796	4 350	5 237
БНСУ	17 205	26 754	30 910	17 325	26 758	31 173
БНХАУ	91 934	141 473	171 422	88 321	138 053	166 064
Герман	4 999	8 826	8 204	5 123	8 020	7 625
Дани	438	1 003	763	440	902	737
Казахстан	1 785	3 144	4 044	1 521	3 324	3 825
Канад	1 149	2 340	2 320	1 098	2 430	2 332
Нидерланд	697	3 144	2 681	795	2 726	2 803
ОХУ	53 330	55 563	62 151	45 538	55 654	62 110
Швед	993	2 071	1 927	909	2 071	1 918
Швейцари	642	2 233	-	580	2 233	-
Франц	2 751	5 567	5 843	2 866	5 288	5 717
Япон	7 757	13 196	13 014	7 728	13 080	12 869
Бусад	10 489	21 811	22 486	11 190	20 237	22 151

Эх үүсвэр: 2005 оны Монгол улсын статистикийн эмхтгэл, Улаанбаатар, 2006 он

2005 онд манай улсад ирсэн нийт гадаад зорчигчдын 50 хувь нь Хятад улсаас, 18 хувь нь ОХУ-аас, 9 хувь нь Солонгос улсаас ирсэн нь хамгийн их байна. Өөрөөр хэлбэл манай улсад зорчигч гадаад иргэдийн 70 орчим хувь нь хөрш зэргэлдээ орноос ирж байна. Гадаадаас ирж байгаа иргэдээс нилээд нь манай улсад хөдөлмөр эрхлэхээр ирж байна. Гадаадын гэрээт ажилчдын ихэнх нь барилга, уул уурхайн салбар, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт ажиллаж байна. 2004 оны эхээр гэхэд Нийгмийн

хамгаалал хөдөлмөрийн яаманд бүртгэлтэй 8000 гаруй гадаад ажилчид байгаагийн 36 хувь нь хятад, 22 хувь нь орос, 22 хувь нь украин ажилчид байсан байна. Ажилгүйдлийн бодит түвшин өндөр, ядуурал ихтэй манай улсын хувьд гадаад ажилчдыг авчрах нь тийм ч зохистой биш. Гэвч бизнес эрхлэгчдэд зам тээвэр, барилга зэрэг салбарт гадаад ажилчдыг ажиллуулах нь монгол ажилчид ажиллуулснаас илүү ашигтай байдаг гэнэ. Энэ нь хятад ажилчдын хөдөлмөрийн сахилга, бүтээмжтэй холбоотой. Бас хулгай хийхгүй зэрэг өөр давуу тал ч байдаг бололтой.

Монгол улс Хятадтай хил зэргэлдээ байдаг нь Хятадын иргэд манай улсаар дамжин хөгжилтэй орнуудад худалдаа наймаа эрхлэх завсрын дамжлага болдгоос гадна хуурамч бичиг баримтаар манай улсын иргэн гэж гуравдагч оронд гарах оролдлого ч гарч байна. Энэ нь манай улсад хүний наймааны бизнес эрхлэх сонирхлыг төрүүлж энэ асуудалд Хятад, Солонгос, Япон улсын зарим иргэд холбогдсон баримт байна.

Хэрэв гадаадын иргэд манай улсад 30-аас дээш хоног байх болбол Гадаад иргэдийн бүртгэлийн газар юм уу, эсвэл түүний харьяа орон нутгийн байгууллагад бүртгүүлэх ёстой. Гэвч манай улсад виз хэтрүүлсэн тохиолдол байнга гардаг байна. Зөвхөн 2003 онд гэхэд л 2000 орчим гадаадын иргэд визаг хэтрүүлэн торгуулсан байна. Гадаадаас манай улсад шилжин ирж байгаа гадаад иргэдтэй холбоотой эерэг сөрөг олон баримт дурьдаж болохоор байгаа.

1990 оноос хойш гадаадад зорчих монгол иргэдийн тоо ч эрс ихэссэн. Зөвхөн 1990-1999 онд гэхэд 30 дахин нэмэгдсэн байна. Одоогийн байдлаар албан бус тоогоор МУ-ын 113 мян гаруй иргэн гадаадад оршин сууж байна. Үүнээс нилээд хувь нь БНСУ, АНУ, ХБНГУ-д, бусад нь ОХУ, Англи, Япон, Чех, БНХАУ, Польш зэрэг улсуудад ажиллаж амьдарч байна. Хүмүүсийг гадаад руу шилжихэд нөлөөлж байгаа хүчин зүйл бол манай улсын эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал, тухайлбал, ажилгүйдэл, хүн амын цалингийн үнэлэмж бага байгаа явдал мөн.

Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, НҮБ-ын Хүн амын сан, Монголын хүн ам хөгжил нийгэмлэгээс АНУ, БНСУ, БНЧУ зэрэг улсад явуулсан “Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар судалгаа болон бусад олон мэдээллээс үзвэл шилжин явагсад өөрийн зорилгыг гэрээт ажил хийх, ажил хайх, сурах гэсэн байна. БНСУ-д ажиллагсдын 85 % нь эдийн засгийн байдал муу, ажилгүй байсан гэж хариулсан байхад, АНУ-д ажиллагсад гадаад явах болсон шалтгаанаа сурах гэж хариулсан боловч ихэнх нь одоо эргэж ирээгүй хүмүүс байна. Гадаадад ажиллаж байгаа монголчуудын

дийлэнх нь 20-35 насныхан байна. Насны хувьд Солонгос улсад ажиллагсдын дунд 40-44 насныхны эзлэх хувь харьцангуй өндөр байна. Гэрлэлтийн байдлыг үзвэл Солонгос улсад гэр бүлээрээ ажиллах явдал харьцангуй их, харин АНУ-д ганц бие залуучууд олон байна. Боловсролын хувьд гадаадад ажиллаж байгаа монгол иргэд бүрэн дунд боловсролоос дээш боловсролтой хүмүүс байна.

АНУ-д ажиллагсдын 60% нь, Солонгост ажиллагсдын 50% нь дээд боловсролтой байна. Гэвч гадаадад ажиллаж байгаа монголчуудын ихэнх нь оёдол, барилга, цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэр, худалдаа үйлчилгээний салбаруудад, тухайн улсын иргэд ажиллахыг хүсдэггүй хүнд хэцүү ажлыг хамгийн бага цалингаар хийж байна. БНСУ-д ажиллагсад солонгосчуудаас 1,6 дахин, БНЧУ-д ажиллагсад чехүүдээс 1,4 дахин, АНУ-д ажиллагсад америкчуудаас 1,4 дахин бага цалин авдаг байна.

Монголчуудын ажлын байрны нөхцөл муу, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа хангагдаагүй газарт ажиллах нь олон байна. Ялангуяа БНСУ-д ажиллагсдын хувьд АНУ, БНЧУ-тай байгаа ажиллагсадтай харьцуулахад илүү муу байна. БНСУ-д ажиллаж байгаа 5 хүн тутмын нэг нь хөдөлмөрийн гэрээгүй, ажиллах зөвшөөрөлгүй, визний хугацаа дууссан хүмүүс байдаг байна. Ажиллаж амьдрах зөвшөөрөлгүй ийм хүмүүс эдийн засгийн хувьд хүнд байдалд орох эрсдэл өндөртэйгээс гадна эрх ашгаа хамгаалах ямар ч боломжгүй байна. Гадаадад ажиллагсдын эх орондоо үзүүлэх эдийн засаг, нийгмийн нөлөө их байна. Сүүлийн үеийн албан бус мэдээгээр гадаадад байгаа монголчууд жилд эх орондоо 300 000 доллар шилжүүлдэг гэсэн мэдээ байна.

Судалгаанаас БНСУ-д ажиллагсдын 23% нь хүүхдийнхээ боловсролд, 19% нь байр худалдан авахад хөрөнгө оруулсан байна. Мөн нилээд хувийг хувийн хэрэглээнд, тухайлбал хүнс, хувцас, эм эмчилгээ, сувилгаа, хүүхдийн сургалтын төлбөр зэрэг өрхийн наад захын хэрэгцээнд зарцуулдаг байна. Монгол банкны мөнгөн гуйвуулгын талаарх мэдээлэл, УСГ-ын экспорт импортын мэдээллийг үндэслэвэл тус улсын импортын нийт хэмжээнд гаднаас орж ирж байгаа мөнгөний эзлэх хувийн жин жил тутам хурдтай өсч байгаа бөгөөд 2003 онд импортын 21 хувийг эзэлж байсан байна. Монголчуудын гадаадаас илгээж байгаа мөнгө МУ-д үндэсний орлого, гадаад валютын нөөц нэмэгдүүлэх, импортыг санхүүжүүлэх, МУ-ын төлбөрийн балансыг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулж байна.

Мөнгөөр илэрхийлж болохгүй үр өгөөж нь орчин үеийн үйлдвэрлэл, технологид суралцаж, ажил хийх дадлагатай болж гадаад хэл сурч бизнесийн сэтгэлгээнд ахиц гарах зэрэг үр нөлөө их юм.

Гэвч гадаадад ажиллаж байгаа монголчуудын эрх зүйн байдал хамгийн эмзэг асуудлын нэг юм. Шилжин ирэгсдийн хувьд хүний эрх нь зөрчигдөх ялгаварлан гадуурхагдах, шударга бус янз бүрийн бэрхшээл тохиолдож байна. Мөн тэд үндэстэн ястныхаа хувьд өөрийн онцлог ёс заншлаа уламжлалаа алдах явдал гарна. Манай иргэдийн ажиллаж амьдарч байгаа зарим улсад гадаадын ажиллах хүчний эсрэг ялгаварлан гадуурхалт, хүний наймаанд өртөх явдал гарч байна. Нөгөө талаас шилжих хөдөлгөөн нь хүлээн авч буй орны хувьд ч асуудлыг үүсгэж байна. Тухайн орны хүн амд тодорхой аюул, тухайлбал байгаль орчин доройтох, нийгмийн орчин нөхцөл муудах, ажлын байрны хүртээмж багасгах зэрэг сөрөг талтай байдаг. Эндээс үзвэл энгийн иргэдийн шилжих хөдөлгөөн нь голдуу эдийн засгийн зорилгоор өдөөгдсөн байдаг ч цаашидаа нийгэм соёл аюулгүй байдал, эрх зүйн хүрээг хамарч байна. Манай иргэдийн очиж байгаа улсууд олон улсын эрх зүй гэхээсээ илүү өөрийн дотоод хууль журмыг баримтлан зохицуулалт хийж байна. Гадаадад хууль бусаар ажиллаж амьдарч байгаа монголчуудын бүх талын эрх хаалттай байгаагаас гадна гэрээтэй ажиллагсдын хувьд ч эрх ашгаа хэрхэн хамгаалах талаар оршин сууж байгаа улсынхаа болон олон улсын хууль эрх зүйн мэдлэггүй байна. Түүнээс гадна гадаадад ажиллаж байгаа монголчууд МУ-ын үндсэн хуулиар заагдсан сонгох сонгогдох эрхээ эдэлж чадахгүй байгаа.

Ойрын жилүүдэд гадаадад гарч ажиллах хүний тоо нэмэгдэх хандлагатай байна. Монголчуудын очих улс орон, ажиллах салбарын тоо ч өсөх хандлагатай байна. МУ гадаадад ажиллах хүч экспортолж байна. Бид бараа үйлчилгээ экспортлохдоо ОУБ-д элсэн, олон улсын гэрээ конвенцид нэгдэн орж түүнийгээ биелүүлэх гэж ихээхэн хүч чармайлт гаргаж байгаа. Тэгвэл ажиллах хүчээ экспортолж байгаа өнөөгийн нөхцөлд нэн тэргүүнд анхаарч ахиц өөрчлөлт гаргах шаардлагатай. Үүнд:

- Хилийн чанадад ажиллаж амьдарч байгаа монголчуудын эрх ашгийг хамгаалж байхын тулд ОУХБ, олон улсын бусад байгууллагуудын гэрээ конвенцид нэгдэн орох энэ чиглэлээр болж байгаа олон улсын хурал зөвлөлгөөнд идэвхтэй оролцож гадаадад ажиллаж амьдарч байгаа иргэдийнхээ дуу хоолойг хүргэж байх;

- Монголчууд олноор ажиллаж амьдарч байгаа улс орнуудтай хамтран ажиллах, зөвшилцөх санаачлага гаргах;
- Гадаадад ажиллаж байгаа монголчуудын оршин байгаа газрынхаа хууль эрх зүйн актууд болон ОУ-ын эрхийн актуудын талаар мэдлэгтэй болгох, тэдэнд зөвлөлгөө сургалт зохион байгуулдаг байх;
- Гадаадад ажиллах хүч экспортлож байгаа өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үндэсний хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, шилжин явагсад, ирэгсдийн талаар бодлого төлөвлөлтийг тусгайлан боловсруулах;
- Гадаадад ажиллах хүч экспортлох хөтөлбөр боловсруулж үр дүнд хүргэх;
- Гадаадад байгаа иргэдийн үндсэн хуулиар заасан эрхээ эдлэх, хоёр иргэншлийг зөвшөөрөх талаар асуудлыг анхаарч арга хэмжээ авах;
- Гадаадад ажиллаж байгаа иргэдэд үзүүлэх үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэхэд анхаарах.
- Банк санхүүгийн үйлчилгээ, хөрөнгө оруулалт, бизнес эрхлэхэд зөвлөлгөө өгөх, хөнгөлөлттэй хандах тогтолцоо шаардлагатай байна.

Гадаадад ажиллагсдын ихэнх нь залуучууд байгаа учраас туршлага дутаж, эх орондоо оруулж ирж байгаа мөнгө урсгалаараа үрэгдэх байдалтай байна.

МУ глобалчлалын энэ эринтэй хөл нийлүүлэн алхаж байгаагийн хувьд шинэ шинэ асуудал бэрхшээлтэй тулгарч болзошгүй байгаа. Хүний наймаа, хууль бус шилжих хөдөлгөөн, улс дамнасан гэмт хэрэг зэрэг юм. МУ НҮБ-ын холбогдох конвенциудад нэгдэж эдгээр байгууллагатай хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх шаардлагатай.

Ашигласан материалууд:

1. “Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар” Судалгааны тайлан. 2005 он
2. “Монгол улсын Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро төвшний судалгаа”, МУИС-ийн ХАЗССТөв, 2001 он
3. “Шилжилтийн эдийн засаг дахь ажилгүйдэл: Монголын бодит байдал”, ОУ-ын э/ш-ний бага хурлын материал. 1998 он
4. “Хөдөлмөрийн зах зээлийн асуудал”, ХДС-ийн э/ш-ний бүтээлийн эмхэтгэл. 1999 он
5. “Хөдөлмөр эрхлэлтийн салбарт зарцуулж буй улсын төсвийн хөрөнгөнд хийсэн жендэрийн дүн шинжилгээ”, судалгааны тайлан. 2004 он
6. Д.Эрдэмбилэг “Аль оронд очиж ажиллаваас мөнгөтэй болох вэ?”, 2000 он
7. “Хүн амын шилжих хөдөлгөөний асуудлаархи үндэсний дээд хэмжээний уулзалт” 2005 он
8. 2005 оны Монгол улсын статистикийн эмхтгэл, Улаанбаатар, 2006 он